

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2027 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, ... Улсын Их Хурал 06 дугаар сарын 01-ний дотор батална.” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ.” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үндэсний хөгжлийн хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, бусад төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн хуулийн этгээдийг оролцуулан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 03 дугаар сарын 25-ны дотор Засгийн газарт танилцуулна.” гэж заасан.

Хуульд заасны дагуу иргэд, олон нийт, хувийн хэвшил, иргэний нийгэм, шинжлэх ухааны байгууллагуудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгүүдийг 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 17-ны өдрүүдэд 5 сэдвийн хүрээнд зохион байгууллаа.

1. 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “Байгаль орчин, ногоон эдийн засаг” бүлгийн хүрээнд:

Тус хэлэлцүүлэгт төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл 70 орчим төлөөлөгч оролцож, төлөвлөгөөний төслийн агуулга, зорилт, хэрэгжилтийн арга замын талаар санал, зөвлөмж солилцов.





2. 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр “Хүний хөгжил, нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл” бүлгийн хүрээнд:

Уг хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн 90 орчим төлөөлөл оролцож, нийгмийн тэгш байдал, хүртээмж, хөдөлмөр эрхлэлт ба орлого, соёл, нийгмийн үнэт зүйлс зэрэг чухал асуудлуудын хүрээнд санал, зөвлөмж солилцов.



3. 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр “Эдийн засаг, дэд бүтэц, өрсөлдөх чадвар, бүсчилсэн хөгжил” бүлгийн хүрээнд:

Эдийн засаг, дэд бүтцийн чиглэлийн панел хэлэлцүүлэгт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (Бүсчилсэн хөгжил), Монгол Улсын Шадар

сайдын ажлын алба (Гадаадын хөрөнгө оруулалт)-ны төлөөлөл оролцож, салбарын 2027 онд хэрэгжүүлэх онцлох ажлын талаар танилцууллаа.

Мөн хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус, хувийн хэвшил, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагын нийт 60 орчим төлөөлөл оролцож, “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний төсөлд санал өглөө.



4. 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” бүлгийн хүрээнд:



Шинжлэх ухаан, технологийн салбарын бодлого, хөгжлийн асуудлаар олон талт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт төрийн байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, хувийн хэвшил болон салбарын

эрдэмтэн судлаачид оролцож, бодлогын чиглэл, хэрэгжилтийн талаар санал солилцов.

Хэлэлцүүлгийн хүрээнд шинжлэх ухаан, технологид суурилсан эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлон хэлэлцэв. Үүнд, мэдээллийн технологи, хиймэл оюун, өгөгдлийн эдийн засгийг хөгжүүлэх, төрийн үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нээлттэй өгөгдлийн ашиглалтыг нэмэгдүүлэх асуудлыг онцоллоо.

Түүнчлэн шинжлэх ухаан, технологийн салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилт, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатайг онцоллоо. Түүнчлэн технологи дамжуулалт, оюуны өмч, инновацын үр ашгийг нэмэгдүүлэх, судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар хэлэлцэв.

5. 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Төрийн бүтээмж, засаглал” бүлгийн хүрээнд:

Тус хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Үндсэн хуулийн цэц, Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын харьяа байгууллагууд болон шүүх засаглалын байгууллага, хувийн хэвшлийн зэрэг 20 гаруй байгууллагын 70 орчим төлөөлөл оролцсон.



Эдийн засаг, хөгжлийн яамнаас Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийн танилцуулгыг хийж, төрийн бүтээмж, засаглалын чиглэлээрх панел хэлэлцүүлэгт Батлан хамгаалах яам, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Удирдлагын академийн төлөөлөл оролцож, салбарын хэмжээнд 2027 онд хэрэгжүүлэх онцлох ажил, үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тулгамдаж буй асуудал, гарц шийдэл, бодлого, төлөвлөлтөд оролцогчдын үүрэг оролцооны талаар санал солилцов.

Хэлэлцүүлэгт оролцогчдоос Улсын дээд шүүхийн төлөөлөл шүүхийн байгууллагуудын асуудлыг тусгайлан авч үзэх, Улсын ерөнхий прокурорын газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон мэдээллийн технологийн программ хангамжийг нэмэгдүүлснээр иргэдийн шүүх засаглалд итгэх итгэл нэмэгдэж, үүний үр дүнд авлига буурч засаглал сайжрах, Хүний эрх хөгжил төвөөс салбар дундын байдлаар хэлэлцүүлэг хийж байгаа нь ач холбогдолтой, цаашид бодлогын баримт бичгийн гүйцэтгэлээр хэлэлцүүлэг хийх хэрэгтэй, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд Тогтвортой хөгжлийн зорилготой сайтар уялдаж тусгагдсан, нийтийн эрх ашгийн өмгөөллийн нэхэмжлэл хүлээж авах нь шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, Цагдаагийн ерөнхий газраас цахимжуулалт нь мөрдөх байгууллагуудын ажлын бүтээмжид эерэг нөлөөтэй, гадаад, дотоод аюулгүй байдлыг зэрэг хангах, төлөвлөгөөний төсөлд зарим агентлагуудтай цаг гарган хүлээж авч уулзах саналуудыг хэллээ.

Хэлэлцүүлэгт оролцогчид хөгжлийн төлөвлөлтийг эрсдэлд суурилсан эрэмбийг онцгой анхаарч боловсруулах, бодлогын тогтвортой байдал, салбаруудын уялдааг хангаж нэгдсэн үр дүнд хүрэх, эцсийн дүндээ хүн төвтэй хөгжил дээр улсын хөгжил тогтоно гэдэгтэй санал нэгдлээ.

“Монгол Улсын 2027 оны төлөвлөгөө”-ний төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 17-ны өдрүүдэд 5 бүлгийн хүрээнд амжилттай зохион байгуулж, 350 гаруй хүн оролцож, 100 гаруй санал, зөвлөмж гаргалаа.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2027 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Мөн иргэд, олон нийтээс санал авахаар Эдийн засаг, хөгжлийн яамны цахим хуудсанд “Монгол Улсын 2027 оны төлөвлөгөө”-ний төслийг нээлттэй байршуулсан бөгөөд 190 хүнээс санал, зөвлөмж ирсэн байна.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2027 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТЭСЛИЙН ОЛОН НИЙТИЙН
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЬЁГ

2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Нэр, байгууллага		Санал	Саналын тайлбар
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ			
1	3.Баянзул Хүүхэлдэйн театрын дарга	Хүний хөгжлийн асуудлыг хүүхдүүдээс эхлэх хэрэгтэй. Хүүхдэд төсөвлөсөн төсвийг хасдаг. Номын сан, музей, хүүхдийн театр гэсэн асуудлууд байна.	Туссан. 3.1.1.2.1.Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр барих
2	Д.Нарантуяа Философийн хүрээлэн ЭША	Орлогод нийцсэн орон сууц. Хамгийн чанартайг нь залуучуудад хүргэх хэрэгтэй. Дундаж давхаргын, төлбөрийн чадамжтай залуу гэр бүлээ дэмжих хэрэгтэй.	Туссан. 4.4.1.3.Орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.
3	Б.Тунгалаг "Бүх нийт боловсролын төлөө"	Бүх салбарт салангид хэрэгжиж байгаа боловсролын хөтөлбөрийг нэг салбарт төвлөрүүлэх шаардлагатай.	Туссан. 1.1.3.3.1.Иргэдийн суурь ур чадварыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагаа хэрэгжүүлэх
4	иргэний нийгмийн үндэсний эвслийн Ерөнхий зохицуулагч	Ядуу өрхийн хүүхдүүд боловсролын шууд бус зардлаас болж хичээл завсардаж байна. Ядуу өрхийн хүүхдүүд рүү чиглэсэн халамж, боловсролын дэмжлэгийн талаар ажил оруулах.	Туссан. 4.1.2.1.1.Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх
5	Монголын скаутын холбоо	Эрүүл мэнд, амьдрах ухаан зэргийг хамруулсан хөтөлбөрт багш нарын зардлыг даагаад сураач гэтэл багш нар хөдлөхгүй байна. Багш нарын манлайллыг сайжруулахад Боловсролын яам анхаарах.	Тусаагүй. Боловсролын яаманд хэлсэн санал тул тусгаагүй.
6	Г.Оюунбаяр	Сум хөдөө орон нутгийн сургуулийн интернэтийн хүрэлцээ холбож байгаа ч 1GB-ээс дээш байх шаардлагатай байна. Дата үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад ДНБ 2.4 хувиар өсдөг олон улсын зүй тогтол байдаг.	Туссан. 5.8.1.1.1."Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар хяналтыг сайжруулах" төслийг хэрэгжүүлэх
ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ, БҮСИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ			
7	Б.Зандан Хөрөнгө оруулалт, худалдааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	1. Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх 2. Хөрөнгө оруулагчдад үйлчлэх төвийн төсөл чухал байна.	Туссан. 9.1.3.1.1.Гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх төрийн бүх үйлчилгээг багтаасан "Цахим нэг цонхны үйлчилгээ"-г сайжруулах 5.5.1.1.1.Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын санхүүгийн төв болсон улс

			<p>орнуудад сурталчлан таниулж гадаадын хөрөнгө оруулагчдыг татах олон улсын арга хэмжээ зохион байгуулах</p>
8	<p>Ч.Болдбаатар ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч</p>	<p>Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.</p>	<p>Туссан. 5.1.1.1.Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ. 5.1.2.1. Малын гаралтай түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлнэ 5.1.2.2.Хөнгөн үйлдвэрийн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ. - гэсэн үр дүнгүүдийн хүрээнд 12 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн.</p>
9		<p>Хөнгөлөлттэй зээл олголтыг сайжруулах.</p>	<p>Туссан. 2.1.3.1.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх</p>
10		<p>Гарааны компаниудыг дэмжих.</p>	<p>Туссан. 2.1.3.1.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх</p>
11		<p>Дотоодын хэрэгцээг хангах хүнсний аюулгүй байдлыг сайжруулах</p>	<p>Туссан. 4.3. Хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.— гэсэн салбарын үр дүнгийн хүрээнд дараах арга хэмжээг төлөвлөсөн. 4.3.1.1.Хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх 4.3.1.1.2.Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжид орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээний аргаар нийлүүлэх 4.3.1.2.1.Малын дайвар бүтээгдэхүүн экспортлох эрх зүйн орчныг</p>

			бүрдүүлэх, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протокол байгуулах
12	Ё.Энхтуяа Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч	Суурилагдсан хүчин чадлыг +1000 МВт-аар нэмэгдүүлнэ.	Туссан. 5.6.1.1.1.Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх 8.1.2.6.1.Мандалговьд 100 МВт-ын салхин цахилгаан станцын төслийг төслийн сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэх 5.6.1.1.4.Дулааны II цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн 300 МВт-ын хүчин чадалтай "Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)" төслийг хэрэгжүүлэх
13		Цайдам нуурын уурхайд түшиглэсэн 660 МВт станц байгуулах.	Тусаагүй.
14		Багануурын станцууд Эрдэнэбүрэнгийн УЦС → 70–80% гүйцэтгэлд хүргэнэ.	Туссан. 8.1.2.2.1.Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх
15		Айл өрх, ААН-үүдийг сэргээгдэх эрчим хүч ашиглах нөхцөл бүрдүүлэхэд дэд станцын хүчин чадлыг өргөтгөх шаардлагатай	Туссан. 6.2.2.1.1.Гэр хорооллын айл өрхийн бага оврын нарны эх үүсгүүрийг нэмэгдүүлэх 8.1.2.2.2.Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр /6 аймагт нийт 115 МВт нар болон 67 МВт-ын хүчин чадалтай батарей хуримтлуурын станц/-ийн төслийг хэрэгжүүлэх
16	Ц.Өнернасан АҮЭБЯ-ны Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга	Уул уурхайн боловсруулалтыг нэмэгдүүлэх	Туссан. 5.1.1.1.5."Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн кокс, эрчим хүчний үйлдвэрийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх 5.1.1.1.7.Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Хүрэн нүүрснээс хагас кокс

			эрчим хүч үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх
17	Хууль эрх зүйн шинэчлэл хийж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.		Туссан. 5.6.1.4.1.Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх
18	Эрчим хүч ба технологи нэвтрүүлэх.		Туссан 5.6.1.2.1.Горим тохируулгын үүрэг гүйцэтгэх өөрийгөө цэнэглэх эх үүсвэр бүхий их, бага чадлын батарей хуримтлуурын төслийг хэрэгжүүлэх
19	Хөрөнгө оруулалтын бүтэц		Туссан. 5.6.1.4.2.Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах зорилгоор цахилгаан станцын тоног төхөөрөмжид гаалийн хөнгөлөлт үзүүлэх эрхгүйн орчныг бүрдүүлэх
20	Газрын тосны үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх нь стратегийн ач холбогдолтой.		Туссан. 5.1.1.1.1.Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах
21	Алт цэвэршүүлэх үйлдвэр нэн тэргүүнд яригдах чухал байна.		Туссан. 5.1.1.1.4.Алт цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын бэлтгэл ажлыг хангах
22	Гол түүхий эд болох нүүрс, зэсийн экспортыг тогтвортой байх шаардлагатай.		Туссан. 8.1.2.3.1.Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын бэлтгэл ажлыг хангах 5.1.1.1.5."Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн кокс, эрчим хүчний үйлдвэрийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх 5.1.1.1.7.Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Хүрэн нүүрснээс хагас кокс эрчим хүч үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх

23	Д.Мөнхжаргал "Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ-ын Бүсчилсэн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга	Хэт төвлөрлийг хэрхэн задлах гэсэн энэ тал руу илүү чиглэх нь зүйтэй байна.	Туссан. Үндэсний үр дүн: 8. Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгана.- үр дүнгийн хүрээнд 8.1.2.Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлнэ. 8.1.1. Бүс, орон нутгийн хүний хөгжлийн зөрүүтэй байдлыг бууруулна. Салбарын үр дүн тодорхойлж 14 төслийг тусгасан.
24		Бүсийн болон дэд бүтцийн нэгдсэн хүрээнд төлөвлөж, хоорондын уялдааг хангах шаардлагатай.	Туссан. Үндэсний үр дүн: 8. Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгана.- үр дүнгийн хүрээнд 8.1.2.Орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлнэ. 8.1.1. Бүс, орон нутгийн хүний хөгжлийн зөрүүтэй байдлыг бууруулна. Салбарын үр дүн тодорхойлж 14 төслийг тусгасан.
25	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төлөөлөл	Мэдээлэл технологийн компаниудыг дэмжих грант олгох, татварын дэмжлэг үзүүлэх ажил хамгийн чухал нь байна.	Тусаагүй.
26	Зам, тээврийн яамны төлөөлөл	Хил дамнасан (боомтын) төмөр зам.	Туссан. 5.7.1.3. Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлж, зорчих хугацааг бууруулна: 5.7.1.3.1.Гашуунсухайт - Ганцмод боомтын хил дамнасан 19.5 км төмөр зам барих 5.7.1.3.2.Ханги - Мандал боомтын хил дамнасан төмөр зам барих 5.7.1.3.3.Шивээхүрэн - Сэхээ боомтын хил дамнасан холболтын төмөр зам барих
27		"Мухар" төмөр замуудыг холбох.	Туссан. 5.7.1.3. Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлж, зорчих хугацааг бууруулна.
28		Төмөр замын сүлжээг өргөтгөх.	Туссан.

			5.7.1.3. Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлж, зорчих хугацааг бууруулна. Туссан.
29	Авто замын сүлжээг өргөтгөх.		5.7.1.2. Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн шинэчилж, бүсийн төв, нийслэл хоорондын зорчих хугацааг бууруулна. Тусгаагүй.
30	Азийн авто зам АН-3 төслийг дуусгах.		Туссан.
31	Боомтуудыг хооронд нь бүрэн холбох. Шинэ/чухал боомтууд: Ханх, Хатгал, Бичиг (төслүүд хэрэгжиж байгаа)		5.7.1.1. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ. – үр дүнгийн хүрээнд 17 төсөл туссан.
32	Аймаг хоорондын зам, сүлжээг бүрэн холбож дуусгах.		Туссан. 5.7.1.2. Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн шинэчилж, бүсийн төв, нийслэл хоорондын зорчих хугацааг бууруулна.
33	Тээвэр логистикийн төвүүдийг зэрэг хөгжүүлэх. Тээвэр + хадгалалт + дамжуулалт → нэгдсэн систем		Туссан. 5.7.1.2.4. Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх 8.1.2.6.2. Говьсүмбэр аймгийн Чойр хотод хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистикийн хуурай боомт бүхий чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг хангах
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИ, ХИЙМЭЛ ОЮУН УХААН САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ			
34	Б.Туул Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч	Оюуны өмчийн газрын мэдээллээр оюуны өмчийг үнэлэх аргачлал байдаггүй байсан. Саяхан анх удаа Сангийн сайд ЭЗХ-ын сайдын хамтарсан аргачлалтай болсон. Тэгэхээр оюуны өмчийг үнэлэх боломжтой болж байна. Хувийн хэвшилтэй хамтраад явж байна.	Туссан. 10.1.1.2. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна. 10.1.1.2.1. Технологиг дамжуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх
35	Б.Авид,	Бодлогын хэрэгжилтийг салбар бүрээс хамаараад тохирсон үнэлгээгээр үнэлэх нь зүйтэй.	Хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй хамаарахгүй тул тусгаагүй.

	Шинжлэх ухааны академийн Дэд ерөнхийлөгч, академич		
36	Т.Атарсайхан, ЭЗХЯ-ны харьяа Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Доктор	Гарч байгаа бүтээлүүд өөр өөр боловч санхүүжилтийн нэг эх үүсвэр дээр явж байна. Дараагийн бүтээлээ гаргахад хувийн хэвшлээ орж ирэх боломжтой болгох нь зүйтэй. Үнэлгээг хувийн хэвшил бусад салбар өөрсдөө дүгнэдэг. Үр өгөөжийн талаар эрх зүйн баримт бичигт бичсэн байдаг ч хэрэгжилт байхгүй байна.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
37	Б.Эрдэнэ ЦХИХХЯ-ны Хиймэл оюун, их өгөгдлийн хэлтсийн дарга	Энэ улс орны өрсөлдөх чадварыг бүрдүүлэх чухал зүйл байдаг. Яамны зүгээс урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт оруулаад явж байна. Үндэсний их өгөгдлийн санг эхлүүлээд явж байна. Өгөгдлийн тухай хуулийн хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг хийгээд явж байгаа ба тухайн үр дүнгээс хамаараад хуул, эрх зүйн орчин бүрдэнэ.	Туссан. 8.1.1.2.2.Хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан орон зайн төлөвлөлтийн систем хөгжүүлэх
38		Цахим яам өгөгдлийн эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх ажлыг бодлогоор дэмжээд явахад болох зүйл. Төрийн байгууллагууд хоорондоо мэдээллээ хуваалцаад явмаар байна. Өгөгдлүүд нэгдсэн платформ хийхэд болох ажил.	Туссан. 10.2.1.1.1.Хиймэл оюуны “Үлэн тооцооллын график процессор” суурьтай дэд бүтцийг бий болгох
39	Математик хүрээлэн	Жилийн төлөвлөгөөнд Иргэдэд зориулсан сургалт гэхээсээ илүү ахисан түвшинд хэдэн оюутан хамрагдсан байна гэж оруулъя.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
40	Инженер Бямбабаяр	Төлөвлөгөөний апп хэрэгтэй байна. Үр дүнд хэмжсэн, үр дүнг мэдэж болох боломжтой байдаг.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
ТӨРИЙН БҮТЭЭМЖ, ЗАСАГЛАЛ САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ			

41	Д.Баасандамба, Батлан хамгаалахын дэд сайд	Хөгжлийн асуудалд анхаарч байгаа ч эрсдэлийн үнэлгээг эрэмбэлж тусгах. Хөгжлийн төлөвлөгөөг эрсдэлд суурилсан эрэмбийг онцгой анхаарч боловсруулах, бодлогын тогтвортой байдалд илүүтэй анхаарах шаардлагатай байна.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
42	Ц.Шинэбаяр, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга	Шүгэл үлээгчийн хууль батлах шаардлагатай байна. Авлигыг тэвчих соёл хандлагыг бий болгох ажлыг олон нийтэд чиглүүлж үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал байна.	Туссан. 7.1.1.1.2.Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах
43	Л.Санжрагчаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлд заасан Монгол Улсын засаглалын 3 салбарын нэг гэдгийг анхаарах. Цахим танилцуулгад шүүхтэй холбоотой юу ч байхгүй байна. Шүүхийн салбарт 10 төсөл, арга хэмжээний санал өгсөн, ЗГ-т танилцуулахад 3 нь орсон байсан. Энэ төсвөөр хүссэн үр дүнд хүрч чадахгүй, саналаа дахин эрэмбэлээд өгнө. Саналыг механик байдлаар битгий хасаарай. Төрийн эрх мэдлийн 3 тулгуурын нэг гэж хандаарай. Цахимжуулах асуудал тулгарч байна. Саналаа эрэмбэлээд 4 санал өгье.	Тусаагүй.
44	Ж.Жаргал, Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн захирал	Асуудлаас гаргах арга зам, яаж хэрэгжүүлэх, яаж хариуцлагажуулах вэ гэдэг асуудал чухал байна. Нэгдсэн уялдааг хангаж үр дүнд хүрэх нь чухал байна.	Туссан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
4	Д.Ууганбаяр, Улсын дээд шүүхийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга	Шүүхийн байгууллагыг засаглалын хувьд 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгайлан авч үзэх шаардлагатай байна. Шүүхийн саналуудыг тусгахад анхаарах.	Туссан.
46	Н.Ганболд, Улсын ерөнхий прокурорын газрын Бодлого төлөвлөлт,	Мэдээллийн технологийн программ хангамж хасагдсан байна. Прокурорт мэдээллийн технологи хаягдчихаар бид яах вэ, төлөвлөлтийн уялдаагүйгээс асуудал хүндэрвэл яах вэ, саналыг тусгаж өгөөрэй.	Тусаагүй.

	<p>хяналт шинжилгээ үнэлгээний газрын ахлах прокурор</p> <p>Г.Уранцзоож /Тэргүүн/, Хүний эрх хөгжил төв</p>	<p>-Салбар дундын байдлаар хэлэлцүүлэг хийж байгаа нь ач холбогдолтой болж байна. Цаашид бодлогын баримт бичгийн гүйцэтгэлээр хэлэлцүүлэг хийх хэрэгтэй.</p> <p>-Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд Тогтвортой хөгжлийн зорилготой сайтар уялдаж тусгагдсан. Нэмж уялдуулах үзүүлэлт ЛХЗ 14.1.7, 14..... зэрэг үзүүлэлт/ байна.</p> <p>-Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд иргэний нийгмийн байгууллагууд саналаа өгөх хэрэгтэй.</p> <p>-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг нээлттэй ил тод болгоход анхаарах хэрэгтэй. Бодлогын баримт бичгийн тайлан олддоггүй асуудал байна.</p> <p>-Нийтийн эрх ашгийн өмгөөллийн нэхэмжлэлийн тоо гэсэн шалгуур үзүүлэлт байвал сайн байна. Нийтийн эрх ашгийн өмгөөллийн нэхэмжлэл хүлээж авах нь шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.</p>	<p>Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авч, тусгасан.</p>
47	<p>Мөнх-Итгэл, Цагдаагийн ерөнхий газар, хурандаа</p>	<p>Цахимжуулах асуудал мөрдөх байгууллагуудын ажлын бүтээмжид нөлөөлдөг.</p> <p>Гадаад, дотоод аюулгүй байдлаар зэрэг хангаж байж аюулгүй байдал хангагдана. Цаг гаргаад байгууллага, агентлагуудыг хүлээн авбал тайлбар, мэдээлэл өгөхөд бэлэн байна. Уулзалтын цаг гаргаарай.</p> <p>Хөгжлийн төлөвлөлтийг эрсдэлд суурилсан эрэмбийг онцгой анхаарч боловсруулах, бодлогын тогтвортой байдал, салбаруудын уялдааг хангаж нэгдсэн үр дүнд хүрэх, эцсийн дүндээ хүн төвтэй хөгжил дээр улсын хөгжил тогтоно.</p>	<p>Туссан.</p>
48		<p>БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ЭДИЙН ЗАСАГ САЛБАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</p>	
49	<p>Даваадорж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам</p>	<p>Агаарын бохирдлыг бууруулахад эх үүсвэрийн технологийн шинэчлэл хамгийн чухал.</p> <p>Хатуу түлш хэрэглэж байгаа нөхцөлд бохирдол үргэлжилнэ.</p>	<p>Туссан.</p> <p>6.2.1.1.1.Аймгийн төвүүд болон хот, суурин газрын агаарын чанарыг сайжруулах яндангүй бүсийг тогтоож, мөрдүүлэх</p>

	Санхүүжилтийн механизм- Карбон кредитийн механизмгаар санхүүжүүлээд явах. Олон улсын хамтын ажиллагааны хувьд Сингапур, БНСУ, Япон зэрэг улсуудтай хамтарч санхүүжилт татах боломжтой. MRV системийг нутагшуулах. Ингэснээр карбон зах зээлд оролцох, санхүүжилт татах боломж нэмэгдэнэ.	6.2.1.1.2.Хот, суурин газрын агаарын бохирдлын эх үүсвэрийг бууруулах нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
50	Батдорж, ЦУОШГ-ын Технологи инновацын хэлтсийн дарга	Тусаагүй.
51	Мягмарсүрэн, Эрчим хүчний Зөвлөл ТББ	Туссан.
52	Рэнцэндорж	Туссан. 8.1.2.2.2.Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр /6 аймагт нийт 115 МВт нар болон 67 МВт-ын хүчин чадалтай батарей хуримтлуурын станц/-ийн төслийг хэрэгжүүлэх
53	Г.Галтайхүү, Монголын Байгаль орчны Иргэний зөвлөл (МБОИЗ)-ийн тэргүүн	Туссан. 6.2.1.4.1.Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах төслийн бэлтгэл ажлыг хангах

54	<p>Ариунболд, Эрчим хүчний яам</p>	<p>Одоогийн эрчим хүчний салбарт гол асуудал нь хөрөнгө оруулалтын өрсөлдөөн, төслүүдийн санхүүжилтийн хязгаарлалт болж байна. Томоохон төслүүд (жишээ нь батарей хуримтлуур, дулааны станцууд) нь их хэмжээний хөрөнгө шингээж байгаа тул нөлөөллөөр нь эрэмбэлэх хэрэгтэй. Цахилгаан дамжуулах шугам (ЦДАШ) Батарей хуримтлуур болон ус хуримтлуулах зэрэг энерги хадгалах технологи юм. Эдгээр 2 чиглэлд тусгай арга хэмжээ, бодлогын дэмжлэг зайлшгүй шаардлагатай.</p>	<p>Туссан. 8.1.2.2.2.Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр /6 аймагт нийт 115 МВт нар болон 67 МВт-ын хүчин чадалтай батарей хуримтлуурын станц/-ийн төслийг хэрэгжүүлэх 8.1.2.2.1.Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх</p>
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ЦАХИМ ХУУДСААР ИРҮҮЛСЭН САНАЛ			
1	<p>Шинээр оруулах санал: Монгол улсын хэмжээнд Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх буюу пуужин, газрын генераторын түлш худалдан авч улсын хэмжээний нөөц бүрдүүлэх. 700ш пуужин, 300ш түлш авах. 1.5 тэрбум төгрөг шаардлагатай.</p>	<p>Туссаагүй.</p>	
2	<p>Хүлэмжийн хийг бууруулах тогтвортой ХАА-г дэмжих, бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойд хяналт тавих, малаас гарч буй дайвар бүтээгдэхүүнээс био-бордоо үйлдвэрлэх, сургалт хийх тэдгээрээр ажилдаг ЖДҮ-ийг дэмжих, Үр дүнд; хөрсний доройтлыг хязгаарлах, нөхөн сэргээх малчид мах зарахаас гадна бордоо зарж болно.</p>	<p>Туссан.</p>	
3	<p>ХСҮТ-2, ХӨСҮТ-2 хасах. Монгол Улс эмнэлгийн ор буюу эмнэлэг, эмчийн тоогоороо дэлхийд эхний 10 дотор байна. Эмнэлгийн амбулатори, орны фронт ашиглалт 60% орчим байхад шинэ эмнэлэг хэрэгтэй юу.</p>	<p>Туссан.</p>	
4	<p>Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэхдээ тусгайлсан салбарыг эвч үзэж байгаа нь нэгдсэн байдлыг алдагдуулах, цалин хөлсний хэт ялгаа үүсгэж байгаа тул нэгдсэн байдлаар авч үзэх нь зүйтэй байна.</p>	<p>Туссан. 2.1.2.1.2.Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн зөрүүг арилгах, цалин хөлсний бүтцийг оновчтой болгох</p>	
5	<p>Тэтгэврийн дундаж хэмжээ нэмэгдүүлэхэд хэрэгцээ байгаа боловч НД-ын ерөнхий хуулиар жил бүр нэмэгдүүлж явна гэж заасан байгаа тэхээр энэ хэмжээнээс илүү нэмэх эдийн засгийн боломж бий юу?</p>	<p>Туссан. 2.2.1.1.1.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах 2.2.1.2.1.Хувийн нэмэлт тэтгэвэрт хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх</p>	
6	<p>Эрүүл идэвхтэй амьдрал, нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр хийгдэх ажлуудыг тусгах.</p>	<p>Туссан.</p>	

		1.2.2.2. Биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна.
7	Зарим арга хэмжээний нэршлийг өөрчлөх, төлөвлөгөөнд тусгасан санхүүжүүлдэггүй арга хэмжээг хасах.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
8	Салбар дундын асуудал болох орчны эрүүл мэндийн хөтөлбөрийг 5 яамны хамтын ажиллагаа байдлаар оруулах.	Туссан.
9	Дээд боловсролын салбарын багш, судлаачийг дэмжих, судалгааны тэтгэлэг санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх.	Туссан. 1.1.3.2.1.Тэргүүлэх чиглэлээр суралцаж буй оюутнуудад чиглэсэн санхүүгийн дэмжлэгийн механизмыг шинэчилж Боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгон өөрчлөх
10	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга хасах Уламжлалт эмийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гэхээсээ чанарын шаардлага хангуулах.	Туссан.
11	Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 2027 онд эхлүүлэхээр туссан Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театрын шинэ барилга тусгаагүй байна.	Туссан. 3.1.1.2.1.Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр барих/
12	Хүний хөгжлийн чиглэлийн Эрүүл мэндийн салбарт хийж хэрэгжүүлэх бүтээн байгуулалтад "Асран, сувилах үйлчилгээний төв"-ийг байгуулах ажлыг ажил хэрэг болгон судалж, төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй байна. Энэ нь өрх иргэдэд үүсэж буй байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч гэртээ суух бус тэтгэвэр, тэтгэмжийг нь өгөөд тухайн төвд байрлуулах явдал юм. Ингэснээр өрх, иргэн сурч боловсрох, хөдөлмөрлөх, цаашлаад өрхийн орлого нэмэгдэх гарц бий болно. Байнгын асаргаа шаардлагатай иргэнийг асрамжийн газар өгөх бус сэтгэл тайван асран сувилуулж, ажил хөдөлмөр эрхлэх боломжийг олгох хэрэгтэй байна. Энэ төвийг байгуулснаар хаягдсан, хаясан мэдрэмж хэн хэн нь авахгүй бөгөөд гэр бүлийн тогтвортой тайван байдал бий болох юм.	Тусаагүй.
13	Нэг жилийн төлөвлөгөө учраас томоохон арга хэмжээг онцолж төлөвлөх.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.

14	Зарим шалгуур үзүүлэлтийг дахин харах.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
15	4.4.1.2.3: Шилжих ажлын тухайд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад батлагдсан үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын үлдэгдэл санхүүжилт болон 2025 оны төсвийн жилд төсвийн орлогын бүрдэлтэй уялдан санхүүжилт буцаан татагдсан төсөл, арга хэмжээнүүдийн саналыг нэг бүрчлэн тооцон хүргүүлсэн болно. 4.4.1.2.3: Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тухайд батлагдсан зураг төслийн дагуу тухай инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн хүчин чадал, технологи үйл ажиллагаа, техникийн шаардлага, хүрэх үр дүнгээс хамаарч тухайн жилд хийгдэх барилга угсралтын ажлыг төлөвлөн, түүнтэй уялдуулж тухайн жилд санхүүжих дүн төлөвлөсөн болно. Иймд Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд туссан дээрх арга хэмжээний тухайн жилд санхүүжих дүнг төлөвлөсөн саналаар тусгахыг хүсье. Дахин тооцох, нөхцөл байдалд суурилсан хүрэх түвшинг тодорхойлох.	Туссан.
16		Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
17	Монгол ёс жудаг сэдвийг бие даасан төсөл болгож төлөвлөж төсөвт тусгах.	Тусаагүй.
18	Боловсролын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмж нэмэгдүүлэх төсөл арга хэмжээг нэмэх. Уламжлалт эмийн үйлдвэрлэлийг дэмжих дээр өөрчлөн найруулах.	Тусаагүй.
19		Туссан. 10.1.1.1.3.Уламжлалт анагаах ухааны судалгаа, сургалт, үйлчилгээний зориулалттай цогцолбор байгуулах
20	Орон нутаг руу татсан шилэн кабелийн тариф маш өндөр, 80000Төг/мбит, энэ нь э/з, иргэдийн боловсрол, эрүүл мэнд, УБ-н түгжрэл зэрэгт сөрөг нөлөө үзүүлдэг. Арилгах арга нь ХХТХ-д өөрчлөлт оруулах.	Тусаагүй.
21	Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театрын цогцолбор барих төслийг нэмж оруулах	Туссан. 3.1.1.2.1.Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр барих

22	Багийн бага сургууль дээр анхаарах. Нэг хүүхдэд ногдох зардал маш өндөр, сурлагын чанар хамгийн доогуур байдаг. Хүүхэд нь цөөрсөн сумын сургуулийн хүүхэд улам цөөрөх магад. Казах тува хүүхдийг зөвхөн сурах бичгээр хангах хангалттай юу, бодлого нь хэрэгжихэд өөр бусад арга хэмжээ хэрэгтэй санагдана. Эх хэлний багш бэлтгэх, хүүхдийн эх хэл дээрээ унших ном гэх мэт Бүх яаман дээр шахуу байгаа боловсролын арга хэмжээг яаж Насан туршдаа суралцахуйн төв рүү уяж хэрэгжүүлэх вэ гэдэг чухал.	Туссан. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн дутагдлыг бууруулах арга хэмжээг тусгасан.
23	Засгийн газраас ирүүлсэн үүрэг даалгавар. Бүх багийн төвийг үүрэн холбооны сүлжээгээр хангах ажлыг нэмэх.	Тусаагүй.
24	Чөлөөт бүсүүдийн төсөл арга хэмжээг хасахгүй байх.	Туссан. 8.1.2.6.2. Говьсүмбэр аймгийн Чойр хотод хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистикийн хуурай боомт бүхий чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг хангах 9.3.3.1.1. "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүний хүрээнд Замын-Үүд чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх 9.3.3.1.2. "Цагааннуур" чөлөөт бүсийн эхний ээлжийн цахилгаан хангамж болон харилцаа холбооны дэд бүтцийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх 9.3.3.1.3. Эрэнцав боомт, Хархорум хот, Гашуунсухайт боомтод шинээр чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг хангах 9.3.3.1.4. Чөлөөт бүсүүдэд импортыг орлох дотоодын хэрэгцээг хангах боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг хангах
25	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Туссан. 2.1.3.1.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх
26	2026 оны төсөвт тусгагдсан үргэлжлэн хэрэгжих томоохон төслүүдийг нэмж тусгах.	Туссан.

27	Гадаад нөхцөл байдлаас үүсэх дэлхийн эдийн засгийн нөхцөлийг сайтар тооцох, уялдуулах.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
28	Монгол Улсын бүх засаг захиргааны нэгжид үүрэн холбооны сүлжээ байгуулах арга хэмжээ. Цагаан нуур чөлөөт бүсэд харилцаа холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах арга хэмжээ. Төрийн цахим үйлчилгээний дахин инженерчлэл хийх шаардлагатай ажил, арга хэмжээ.	Туссан. 7.3.4.2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийн сайжруулалт хөгжүүлэлтийг хийх 7.3.2.2.1.Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цогц системийг хөгжүүлж, төрийн байгууллагуудад нэвтрүүлэх
29	Хархорум хотын Хэлтгийн цагаан нуурыг сэргээх, Төв цэг, төв талбайн тохижилт, I, II ээлжийн авто замын бүтээн байгуулалтын төслүүдийг нэмж тусгах	Тусаагүй.
30	Эрх чөлөөт илүү их болгох буюу хүрээлэнгүүдэд арилжааны данс нээж өөрөө өөрсдийгөө санхүүжүүлэх боломжийг олгох.	Тусаагүй.
31	Шинжлэх ухааны чиглэлд илүү түлхүү дэлгэрэнгүйгээр төслүүдийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.	Туссан. 10.1.1.1.1.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулах, 10.1.1.1.2.Хэрэглээний биотехнологийн төвийг ашиглалтад оруулах, 10.1.1.1.3.Уламжлалт анагаах ухааны судалгаа, сургалт, үйлчилгээний зориулалттай цогцолбор байгуулах, 10.1.1.1.4.Малын эрүүл мэндийн дэвшилтэт технологийн үйлдвэр байгуулах
32	Төлөвлөгөөг оптималь болгодог апп зохиож/худалдаж авч ашиглах нь хэрэгтэй юм байна. Ийм апп 1970-80-аад онд байсан, 5 жилийн төлөвлөгөөний биелэлт нь их зөрж байгаагүй. Сүүлд СЯ, МБ, ҮХГ зэрэгт СЕМ гм апп байсан ч, 3Г ашиглаж байгаагүй, ашигласан ч алдаа ихтэй байв. Ж нь нэг хүнд ногдох днб-г 2050 онд \$15000 гэж 2020 онд гаргасан.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй холбоогүй санал тул тусгаагүй.
33	Хиймэл оюуны ахисан түвшний сургалт, судлаачдыг бодлогоор дэмжих. Хиймэл оюун бүтээгчдийг урамшуулах.	Туссан. 10.2.1.2.1.Хиймэл оюуны чиглэлээр иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах

34	Хүний хөгжил, хугацаат цэргийн алба хаагчдад нийгэмд эрэлттэй мэргэжлийг олгох замаар ажиллах хүчийг нэмэгдүүлэх.	Туссан. 7.7.2.1.1.Хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжлийн сургалтыг зохион байгуулах
35	Улсын дээд шүүхэд Хиймэл оюун ухаан хөгжүүлж нэвтрүүлэх төсөл нь 2026 онд суурь систем буюу шүүхэд зориулсан хиймэл оюуны системийн хөгжүүлэлтийн ажил эхэлсэн. Дээрх төсөл арга хэмжээ ТЭЗҮ хийгдсэн төсөл бэлэн шууд хэрэгжих боломжтой, шүүхийн шийдвэр гаргахад хийгдэх судалгааны цаг хугацааг 60-70 хувь бууруулах, эдийн засгийн хувьд цалингийн хэмнэлт жилд дунджаар 2.5-3.0 тэрбум төгрөг хэмнэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг нэмүүлэх шаардлагатай.	Туссан. 7.2.2.2.1.Хиймэл оюун ухааны программ хангамжийн нэмэлт сайжруулалт хийх
36	Цахимжилт хиймэл оюун ухаан нэвтрүүлэлт нэмэх.	Туссан. 1.1.2.2.1.Багшийн ажлын ачааллыг багасгах зорилгоор багш бүрд хиймэл оюунд суурилсан “Нэг багшид нэг хиймэл оюун туслах”-ыг нэвтрүүлэх 7.2.2.2.1.Хиймэл оюун ухааны программ хангамжийн нэмэлт сайжруулалт хийх 7.2.2.4.1.Сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах 7.3.1.1.2.Төрийн албаны хуулийн хэрэгжилтэд (томилгоо) хяналт тавихад хиймэл оюуныг ашиглах 7.4.1.1.1.Цахим парламент болон нийтийн өргөдлийн системийг хууль тогтоох ажиллагааны дижитал экосистем болгон хөгжүүлэх 7.7.1.3.1.Нисгэгчгүй нисэх хэрэгсэл, хиймэл оюунд суурилсан дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх 8.1.1.2.2.Хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан орон зайн төлөвлөлтийн систем хөгжүүлэх 9.1.4.1.1.Стандартын болон лабораторийн үйл ажиллагааг түргэвчилсэн шинжилгээ, хиймэл оюун ашиглан автоматжуулах

		10.2.1.1.1.Хиймэл оюуны “Үүлэн тооцооллын график процессор” суурьтай дэд бүтцийг бий болгох
37	Шинээр боловсруулж байгаа, аргачлалыг яаралтай боловсруулж батлуулах.	Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөтэй хамааралгүй санал тул тусгаагүй.
38	Салбарын албан хаагчид тооцоо судалгаагаар шалгуур үзүүлэлтийг тооцоход анхаарах	Саналыг хүлээн авсан.
39	Арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн нийцлийг хангах нь чухал байх.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулсан.
40	Зарим шалгуур үзүүлэлт оновчтой бус байна.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулсан.
41	Зохистой хөдөлмөрийг АХС-ны оролцоогоор хэмжих нь учир дутагдалтай байна.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулсан.
42	Өнөөгийн нөхцөл байдал нөөцөд суурилсан эсэхээс хамаарч өөрчлөлт оруулах, оновчлох шаардлагатай.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулсан.
43	Хүний хөгжилд, өрх гэр бүлд илүү наалдах бодит үр дүн өгөх шалгуурыг боловсруулах.	Туссан. 4.1.2.1.1.Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4.4.1.3.5.Иргэдийн орлогын түвшинд нийцсэн ипотекийн зээлийн төрөлжилтийг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх
44	1.1.2 иргэдийн биш суралцагчдын гэж өөрчлөх ЕБС-д сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувь биш. Тухайн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэд нь хамрагдсан гэдэг чухал 1.1.3.3 боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бүх яамыг нэмэх.	1.1.3.3.1.Иргэдийн суурь ур чадварыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан тогтсон нэршил тул тусгаагүй

45	Ерөнхийдөө нийцэж байна. 5 жилийн үндсэн чиглэлд орсон бөгөөд, 2026, 2027 онд хасагдаж байгаа арга хэмжээний үр дүнг тооцохдоо хэрхэн тооцов вэ? Тайлант хугацаа болоход хариуцсан яамдын үнэлгээтэй шууд холбогдож, буурдаг.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай хуулийн дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
46	Олон улсын жишиг, стандарттай нийцүүлэн сайжруулах.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай хуулийн дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
47	Бодит хэрэгжилтийг хэмжих тал дээр илүү түлхүү анхаарч хянах.	Төсөл, арга хэмжээний санал бус ерөнхий санал тул тусгаагүй.
48	Шүүх нь боловсрол эрүүл мэндийн байгууллага шиг шууд үйлчилгээ үзүүлдэг байгууллага биш бөгөөд институцын шинжтэй, шударга ёс гэдэг нь КРІ болгоход хүндрэлтэй зэргээс хамаарч шүүх засаглалын хувьд хүндрэлтэй байна, Монгол Улсыг хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний хувьд Төсөл, арга хэмжээ тодорхой • Санхүүжилтийн эх үүсвэр тодорхой • Хариуцагч байгууллага тодорхой • КРІ (шалгуур үзүүлэлт)-тэй • SMART зарчим баримталсан байна.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үр дүн, үр нөлөө, ахиц дэвшлийг хэмжих, хянах зорилгоор тодорхой, бодитой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, хамааралтай (S.M.A.R.T) байх зарчимд нийцүүлэн шалгуур үзүүлэлт, тэдгээрийн зорилтот түвшнийг тодорхойлсон.
49	Оновч багатай өмнөх жил хэрэгжиж суурь бүрдсэн төсөл арга хэмжээг үргэлжлүүлж үр дүнг тооцох.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай хуулийн дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.
50	Шинээр оруулах санал: Монгол Улсын хэмжээнд Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх буюу пуужин, газрын генераторын түлш худалдан авч улсын хэмжээний нөөц бүрдүүлэх. 700ш пуужин, 300ш түлш авах. 1.5 тэрбум төгрөг шаардлагатай.	Тусгаагүй.
51	Монгол улсын хэмжээнд Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх буюу пуужин, газрын генераторын түлш худалдан авч улсын хэмжээний нөөц бүрдүүлэх. 700ш пуужин, 300ш түлш авах. 1.5 тэрбум төгрөг шаардлагатай.	Тусгаагүй.
52	Хүлэмжийн хийг бууруулах тогтвортой ХАА-г дэмжих, бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойд хяналт тавих, малаас гарч буй дайвар бүтээгдэхүүнээс био-бордоо үйлдвэрлэх, сургалт хийх тэдгээрээр ажилладаг ЖДҮ-ийг дэмжих, үр дүнд хөрсний доройтлыг хязгаарлах, нөхөн сэргээх малчид мах зарахаас гадна бордоо зарж болно.	Туссан. 6.3.2.1.1.Малын тэжээлийн ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх
53	ХСҮТ-2, ХӨСҮТ-2 хасах.	ХӨСҮТ-2 хасах саналыг тусгасан.
54	2027 оны төсвийн тухай хуультай уялдах уу?	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасны

		дагуу жилийн төлөвлөгөө, төсөв уялдаж байгаа.
55	Эрүүл идэвхтэй амьдрал, эрүүл чийрэг монгол хүнийг би болгох чиглэлээр ажиллах	Туссан. 1.2.2.1.1.Хүн амын идэвхтэй хөдөлгөөн, спортын талаарх мэдлэг, хандлага, дадал олгох арга хэмжээг зохион байгуулах
56	Хүний хөгжлийн зорилт арга хэмжээнд хүүхдийн хөгжлийг дэмжих хүүхдийн номын санг барих асуудлыг анхаарах	Туссан. 3.1.1.2.1.Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр барих/
57	Санхүүжилтийг илүү бодит болгох, олон хэлэлцүүлгийг явуулах, ард иргэд, иргэний нийгэм, мэргэжлийн холбоодыг оруулах.	Тусаагүй. Төсөл, арга хэмжээний санал бус ерөнхий санал тул тусгаагүй.
58	Эрүүл мэндийн суурь шалтгааныг тусгах.	Туссан. 1.2.1.8.1.Эрт илрүүлэг арга хэмжээг хэрэгжүүлэх
59	Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театрын шинэ барилгыг эхлүүлэх төслийг тусгах.	Туссан. 3.1.1.2.1.Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр барих/
60	Бодлого төлөвлөлтийг хийхэд салбар дундын уялдааг сайжруулах.	Төсөл, арга хэмжээний санал бус ерөнхий санал тул тусгаагүй.
61	Бодлогын яамны санал УИХ-ын түвшинд өөрчлөгддөг, хэт өндөр тоо, хувь болгодог, эсвэл шинэ арга хэмжээ гэнэт нэмэгдэж батлагддаг байдал байсаар байна, бодлогын яамтай заавал зөвлөлдөж санал авч байж тэр саналууд батлагддаг байхад анхаарах хэрэгтэй байна.	Төсөл, арга хэмжээний санал бус ерөнхий санал тул тусгаагүй.
62	Хүний хөгжлийн чиглэлийн Эрүүл мэндийн салбарт хийж хэрэгжүүлэх бүтээн байгуулалтад "Асран, сувилах үйлчилгээний төв"-ийг байгуулах ажлыг ажил хэрэг болгон судалж, төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй байна. Энэ нь ерх иргэдэд үүсэж буй байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч гэртээ суух бус тэтгэвэр, тэтгэмжийг нь өгөөд тухайн төвд байрлуулах явдал юм. Ингэснээр ерх, иргэн сурч боловсрох, хөдөлмөрлөх, цаашлаад өрхийн орлого нэмэгдэх гарц бий болно. Байнгын асаргаа шаардлагатай иргэнийг асрамжийн газар өгөх бус сэтгэл тайван асран сувицуулж, ажил хөдөлмөр эрхлэх боломжийг олгох хэрэгтэй байна. Энэ төвийг байгуулснаар хаягдсан, хаясан мэдрэмж хэн хэн нь авахгүй бөгөөд гэр бүлийн тогтвортой тайван байдал бий болох юм.	Туссан. 4.1.2.2.2.Асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлэх гэрээт байгууллагын тоог нэмэгдүүлэх

63	<p>Дараах асуудлыг урьтал болгох.</p> <ol style="list-style-type: none"> 1. Боловсролын чанарын асуудлыг урьтал болгох 2. Төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх 3. Эрүүл мэндийн даатгалын системийг сайжруулах 4. Хэрэгжүүлэх салбаруудад боломж хүний нөөцийн чадамж байгаа эсэхийг тодорхойлох 	<p>Туссан.</p> <p>Салбарын үр дүн: 1.1. Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.</p> <p>Үндэсний үр дүн: 7. Зөв засаглалын үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.</p>
64	<p>Монгол Улсын Бусчилсан хөгжлийн бодлого, бусад аймгуудын хөгжилд ахиц авчрах төслүүдийг бодитоор тусгах, байршлын хувьд оновчтой төлөвлөх Жн: ХӨСҮТ, ХСҮТ-ийн салбарыг орон нутагт барих.</p>	<p>Тусаагүй.</p>
65	<p>4.4.1.1.1 дэх арга хэмжээний нэршлийн улсын төсөвт туссан нэршлээр буюу "Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт /Говь-Алтай, Есөнбулаг, Улаанбаатар Багануур дүүрэг/ гэж өөрчлөх. үүнтэй холбогдуулан жилийн төлөвлөгөөг боловсруулахад үндэслэж байгаа бусад барим бичгийн хүрэх зорилтот түвшинд өөрчлөлт оруулах боломжтой эсэх.</p>	<p>4.4.1.1.1.Бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих (Дорнод аймаг) гэж туссан.</p>
66	<p>Монгол боловсрол, монгол соёлын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, аюулгүй нийгэм байгуулах төсвийг уялдуулах.</p>	<p>Монгол боловсрол, монгол соёлын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, аюулгүй нийгэм байгуулах асуудлыг уялдуулан төлөвлөсөн.</p>
67	<p>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрыг өөрийн гэсэн байртай болгох.</p>	<p>Тусаагүй.</p> <p>Албан газрыг байртай болгох санал тусаагүй.</p>
68	<p>Хүний хөгжил тэр дундаа хүүхдийн хөгжлийг дэмжих нь чухал байна. "Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театрын цогцолбор барих" төсөл арга хэмжээг тусгах.</p>	<p>Туссан.</p> <p>3.1.1.2.1.Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр барих</p>
69	<p>Шалгуур үзүүлэлт, дата-г хүн амын ялгаатай, наад зах нь 5 бүлгээр гаргах, амьжиргаа, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, байршил/алслагдмал байдал, жөндөр хүйсээр гэх мэт. Ядуурлыг бууруулах, ядуу өрхийн хүүхдийг боловсролд хамрагдахад дэмжлэг үзүүлэх (сурах бичиг, дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл, 4 улирлын хувцас, хичээлээс гадуур секц дугуйланд хамрагдах төлбөрийг даах гэх мэт), боловсролын дэмжлэг ба нийгмийн халамжийн үйлчилгээ дэмжлэгийг хослон үзүүлэх чиглэлээр арга хэмжээ төлөвлөх, ажилгүй боловсролгүй залуус болчихсон хойно арга хэмжээ авах оройдтог.</p>	<p>Туссан.</p> <p>4.1.2.1.1.Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>
70	<p>Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл арга хэмжээг нэмэх.</p>	<p>Туссан.</p> <p>9.3.3.1.3.Эрээнцав боомт, Хархорум хот, Гашуунсухайт боомтод шинээр чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг хангах</p>

		<p>9.3.3.1.1."Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүний хүрээнд Замын-Үүд чөлөөт бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх</p> <p>9.3.3.1.2."Цагааннуур" чөлөөт бүсийн эхний ээлжийн цахилгаан хангамж болон харилцаа холбооны дэд бүтцийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх</p> <p>Туссан.</p> <p>2.1.3.1.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулсан.</p> <p>Туссан.</p> <p>5.1.1.1. Боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн тогтвортой хангалтыг бүрдүүлнэ.</p> <p>5.1.2.1. Малын гаралтай түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлнэ.</p> <p>5.1.2.2. Хөнгөн үйлдвэрийн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ.- үр</p>
71	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд улсын төсөвт суулгах.	
72	Төрийн байгууллагуудын уялдаа хамтын ажиллагааг сайжруулах хамгийн чухал байна. Эрэмбээр дээр байгаа төслүүдэд бодлогоор илүү ач холбогдол өгдөг болохгүй бол татвар төлөгчдийн мөнгө дэмий их үрэгдэнэ.	
73	Төлөвлөгөөний төсөлд салбар яамдаас авсан саналыг үндэслэх, учир нь баримталж буй дунд хугацааны бодлого, төсөвтэй уялдуулсан байгаа.	
74	Яамдаас хүргүүлсэн саналыг дэмжих.	
75	Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг тодорхой арга хэмжээ оруулбал зүгээр юм уу? Ямар арга замаар, ямар бүтээгдэхүүн, түүхий эдийг яаж боловсруулаад, борлуулах нь эдийн засагт хэрхэн нөлөөлөх вэ, шалгуур үзүүлэлт нь юу байх вэ. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хэрхэн хамгаалах вэ? Энэ талаар ямар бодит арга хэмжээ авах вэ?	

		дүнгүүдийн хүрээнд 12 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн тухайлбал: 5.1.2.2.1.Цагаан алт хөдөлгөөний хүрээнд ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгийн зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх
76	Алсын хараа 2050, МУХТЖҮЧ, ЗГҮАХ-т тусгасан зорилт, арга хэмжээтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нараар санал болгосон Хархорум хотын бүтээн байгуулалтын эхний ээлжийн төслүүдийг төлөвлөгөөнд бүрэн оруулж тусгах. Хархорум хотын Хэлтгий цагаан нуурыг сэргээх төсөл, Төв цэгийн цогцолборын төсөл, I, II ээлжийн авто замын төслүүдийг төлөвлөгөөнд нэмж оруулах.	Туссан. 4.4.1.3.4.Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэх 9.3.3.1.3.Эрэнцэв боомт, Хархорум хот, Гашуунсухайт боомтод шинээр чөлөөт бүс байгуулах бэлтгэл ажлыг хангах
77	Супер компьютерын тооцоолох төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын төсвийг 15-аас 18 тэрбум төгрөг болгох саналтай байна.	Туссаагүй.
78	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, биологийн олон янз байдлын судалгааг дэмжих нь чухал байна. Судалгааны үр дүнг бодлого боловсруулах түвшинд ашиглах, их сургууль – судалгааны байгууллага – үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх хэрэгтэй. Мөн залуу судлаачдыг дэмжих санхүүжилтийг нэмэгдүүлж, орчин үеийн лаборатори, технологийн баазыг сайжруулах нь тогтвортой хөгжлийн үндэс болно.	Туссан. 6.2.1.1.2.Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн шинэчилсэн зорилтын хэрэгжилтийг хангах; 6.3.1.3.1.Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтоох
79	Хүрээлэн, төвүүдийг чөлөөтэй санхүүжилт босгоод өөрөө өөрсдийгөө санхүүжүүлээд явах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.	Туссан. 10.1.1.1.1.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулах 10.1.1.1.2.Хэрэглээний биотехнологийн төвийг ашиглалтад оруулах
80	Санхүүжилтийн тал дээр илүү түлхүү анхаарах үүнд нөлөөлж болох бусад хүчин зүйлсийг тооцох.	Шинжлэх ухааны салбарыг дэмжих чиглэлээр ажиллаж байна.
81	Хиймэл оюуны ахисан түвшний сургалт, судлаачдыг бодлогоор дэмжих, хиймэл оюун бүтээгчдийг урамшуулах.	Туссан. 10.2.1.2.1.Хиймэл оюуны чиглэлээр иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах
82	Цахимжилт, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх төсөл арга хэмжээг түлхүү оруулах.	Туссан.

1.1.2.2.1.Багшийн ажлын ачааллыг багасгах зорилгоор багш бүрд хиймэл оюунд суурилсан “Нэг багшид нэг хиймэл оюун туслах”-ыг нэвтрүүлэх

7.2.2.2.1.Хиймэл оюун ухааны программ хангамжийн нэмэлт сайжруулалт хийх

7.2.2.4.1.Сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах

7.3.1.1.2.Төрийн албаны хуулийн хэрэгжилтэд (томилгоо) хяналт тавихад хиймэл оюуныг ашиглах

7.4.1.1.1.Цахим парламент болон нийтийн өргөдлийн системийг хууль тогтоох ажиллагааны дижитал экосистем болгон хөгжүүлэх

7.7.1.3.1.Нисгэгчгүй нисэх хэрэгсэл, хиймэл оюунд суурилсан дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх

8.1.1.2.2.Хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан орон зайн төлөвлөлтийн систем хөгжүүлэх

9.1.4.1.1.Стандартын болон лабораторийн үйл ажиллагааг түргэвчилсэн шинжилгээ, хиймэл оюун ашиглан автоматжуулах

10.2.1.1.1.Хиймэл оюуны “Үүлэн тооцооллын график процессор” суурьтай дэд бүтцийг бий болгох

---oOo---